

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2015.11

Үзүүлэлтүүд:

ДНБ 2.5% 2015 оны III-р улирал	ГШХО 10-р сард 54.5 сая ам.доллар	Төсвийн тэнцэл -1102.2 тэр бум төгрөг	Инфляци 2.9%	Чанаргүй зээл 850 тэрбум төгрөг	Валютын нөөц 1.5 тэрбум ам.доллар
ХАА салбар 12.8%, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2%-иар тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 10-р сарын байдлаар өмнөх сараас 307.4 сая ам.доллар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 168.4 сая ам.доллараар тус тус өссөн үзүүлэлтэй байна.	Төсвийн орлого 5.03 их наяд төгрөг, зарлага 6.13 их наяд төгрөг, тэнцэл (1102.2) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 0.2 хувь өсч, оны эхнээс 2.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.9 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 0.2% буюу 24 тэрбум төгрөгөөр буурч, 850 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 7.1%	Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 10.3 хувь буюу 145 сая ам.доллараар өсч 1542.7 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн
ам.доллартай харьцах
нэрлэсэн дундаж ханш

1992.90



Орон сууцны үнийн индекс

1.067

Өмнөх сараас 0.3%-иар, оны
эхнээс 10.2%-иар тус тус
буурлаа.



Монголбанкны
бодлогын хүү


13%



Арваннэгдүгээр сарын 12-нд бүх нийтээр Их эзэн Чингис хааны мэндэлсний 853 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүллээ. Бүх нийтээр амарсан энэ өдөр төр, засгийн удирдлагууд Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлж “Чингис хаан” одонг зохиолч, яруу найрагч, соён гэгээрүүлэгч Г.Мэнд-Ооёод гардуулав.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629


Эх сурвалж: УЦХороо

Монгол Улс энэ оны эхний 10 сарын байдлаар 18.2 сая тонн нүүрс, 12.5 тонн алт, 975.8 мянган тонн газрын тос олборложээ. Мөн хайлуур жоншны баяжмал 188.1 мянган тонн, зэсийн хүдрийн баяжмал 1,074.4 мянган тонн, төмрийн хүдрийн баяжмал 5.3 сая тонн, цайрын баяжмал 75.2 мянган тонныг тус тус үйлдвэрлэжээ.

ДНБ ДНБ 2015 оны 3-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 11 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 286.4 тэрбум төгрөг буюу эдийн засгийн өсөлт 2.5% болов. Үүнд ХАА салбар 12.8%, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2%-иар тус тус өссөн нь нөлөөлөв. Эдийн засгийн өсөлт ийнхүү удаашралтай байгаа нь аж үйлдвэр, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт бага байгаатай холбоотой.



Төсөв Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ арваннэгдүгээр сард 5.03 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 6.13 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1102.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 709.4 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 11 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.



Валютын ханш Арваннэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 113.10 төгрөг буюу 6 хувь, өмнөх сараас -0.45 төгрөгөөр суларч 1992.90 төгрөгт хүрэв.



Инфляци Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны 11-р сард өмнөх сарынхаас 0.6%, өмнөх оны мөн үеийнхээс 1.9% өссөн байна. Индекс өмнөх сарынхаас өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт 42.1% нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 22.2% нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлт голлон нөлөөлжээ.




* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

Гадаад валютын нөөц Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны 10-сарын байдлаар 1406 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 0.4% буюу 6 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 0.6 хувь буюу 9 сая ам.доллараар өссөн бол оны эхнээс 14.7% буюу 243 сая ам.доллараар буурсан байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс Үнэт цаасны арилжаагаар 2015 оны эхний 11 сард 839.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 29.7 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 671.5 тэрбум төгрөг буюу 5 дахин өсч, арилжигдсан үнэт цаас 14.7 сая ш буюу 33.1 хувиар буурсан байна. ТОП-20 дундаж индекс тайлант сард 12738 нэгж болж, өмнөх сарынхаас 387.1 нэгж, өмнөх оны мөн үеийнхээс 2422.5 нэгжээр буурчээ.



* Монголын хөрөнгийн бирж

Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны арваннэгдүгээр сарын эцэст 9.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 90.9 тэрбум төгрөг буюу 0.9%-иар, өмнөх оны мөн үеэс 118.8 тэрбум төгрөг буюу 1.2%-иар тус тус буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 710.5 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 29.1 тэрбум төгрөг буюу 4.1%, өнгөрсөн оны мөн үеэс 58.4 тэрбум төгрөг буюу 7.6%-иар буурчээ.


Мөнгөний нийлүүлэлт



Хадгаламж

Нийт хадгаламж 2015 оны 11-р сард 7.2 их наяд төгрөг хэвээр байгаа бөгөөд өмнөх сараас 42.5 тэрбум төгрөг буюу 0.4 хувиар буурсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 381.3 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж буурахад төгрөгийн хадгаламж 0.4 хувиар буюу 18.9 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 1.2 хувиар буюу 23.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Хадгаламж



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны арван нэгдүгээр сарын байдлаар 11.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 24 тэрбум төгрөг буюу 0.2%-иар, өмнөх оны мөн үеэс 759 тэрбум төгрөг буюу 6%-иар тус тус буурлаа. Харин чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 850 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.2% (6 тэрбум төгрөг)-өөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 37.1% (230 тэрбум төгрөг)-өөр өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 7.1%-ийг эзэлж байна.


Нийт зээлийн хэмжээ



Ипотекийн зээл

2015 оны 11-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.3 хувь (42.4 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 23.5 хувь (650.3 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.4 их наяд төгрөгт хүрэв. Арваннэгдүгээр сард нийт 706 зээлдэгчид 42.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 76583-д хүрлээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.5 хувь нь төгрөгийн, 1.5 хувь нь гадаад валютын зээл байгаа ба нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.7 хувийг эзэлж байна.

Ипотекийн зээлийн хэмжээ




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа


2015 оны арваннэгдүгээр сард худалдааны нийт бараа эргэлт 7 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 4242.9 сая ам.доллар, импорт 3494.7 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 748.2 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2285 сая ам.доллар буюу 22.8 хувь, үүний дотор экспортын хэмжээ 947.5 сая ам.доллар буюу 18.2 хувиар, импортын хэмжээ 1337 сая ам.доллар буюу 27.6 хувиар тус тус буурчээ. Буурсан гол шалтгаан нь эрдэс бүтээгдэхүүний экспорт 953.6 сая ам.доллар, нэхмэл бүтээгдэхүүнийх 37.8 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөв.



* Эх сурвалж УСХ, МБ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2015 оны аравдугаар сард 54.5 сая ам.долларын эерэг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 168.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.3 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 12.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.



* Эх сурвалж МонголБанк

Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2015 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.5 тэрбум ам.доллар, нийт гадаад өрийн үлдэгдэл 21.4 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 5.3 хувь (199.9 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 0.8 хувь (190 сая ам.доллар)-аар тус тус буурсан байна. Тайлант улиралд Улсын нийт гадаад өрийн 16 хувийг засгийн газрын өр, 10 хувийг Төв банкны өр 9 хувийг, 16 хувийг бусад салбаруудын өр, 49 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 97 хувийг богино хугацаат, 3 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Сарын онцлох үйл явдал**11.11**

"Мандал Женерал Даатгал" ХХК, "Голомт банк", "Монголын бизнесийн зөвлөл" хамтран "Монгол Улсын Эрсдэлийн удирдлагын форум-2015"-г зургаа дахь жилдээ зохион байгуулав.

11.18-19

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Франсуа Олландын урилгаар тус улсад 2015 оны арваннэгдүгээр сарын 18-19-нд албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр хоёр улсын Ерөнхийлөгч нар албан ёсны хэлэлцээ хийж, Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид Бүгд Найрамдах Франц Улсын Сенатын Ерөнхийлөгч Жерар Ларше, Гадаад хэрэг, олон улсын хөгжлийн сайд Лоран Фабиус нар бараалхалаа. Энэхүү айлчлал нь Монгол, Францын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн жил хэрэгжиж буйгаараа онцлог юм.

11.24

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-аас Жижиг дунд бизнес /ЖДБ/ эрхлэгчдийг дэмжих, худалдааны санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор 70 сая ам.долларын зээлийн багц гэрээг Монгол Улсын арилжааны тэргүүлэх банк болох ХААН Банктай байгууллаа.

Тойм**Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн БНХАУ дахь айлчлал**

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 2015 оны 11 дүгээр сарын 9-11-ний хооронд БНХАУ-ын дарга Си Зиньпиний урилгаар БНХАУ-д төрийн айлчлал хийлээ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга Жан Дзэян болон Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэцян нар тус тус бараалхлаа. Айлчлалын дүнгээр хоёр талын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл гаргав. Тус төрийн айлчлалын хүрээнд хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурах ёслол боллоо. Мөн УИХ-ын чуулганы хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт Импорт банк хооронд байгуулах 1 тэрбум ам. долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд, гишүүдийн олонхийн саналаар баталлаа.

Зэс хайлуулах үйлдвэрийг Бор-Өндөрт барина

Цагаан суварга болон Оюутолгойд түшиглэн зэс хайлуулах үйлдвэрийг Бор-Өндөрт барих болсон бөгөөд зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр ашиглалтад орсноор жилд 23 хувийн ашиг өгнө гэсэн урьдчилсан тооцоог гаргаж, төслийн ТЭЗҮ-д ч хөрөнгө оруулалтын зардлаа есөн жилийн хугацаанд нөхөх боломжтой хэмээн Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат танилцуув.